



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/280

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.7, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал” төсөлтэй хамтран санхүүжүүлж буй “Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон Баян-Адарга, Баян-Овоо, Норовлин сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө”-г боловсруулах ажлын хүрээнд газрын доройтлыг бууруулах, биологийн олон янз байдлыг хамгаалах асуудлыг тусгах, шаардлагатай мэдээллээр хангах, санал, дүгнэлт, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, боловсруулсан ерөнхий төлөвлөгөөний төслийг батлуулж хэрэгжилтэд хяналт тавих, жил бүр мониторинг хийх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Салбар дундын мэргэжлийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Л.Батсайхан	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Д.Баярхүү	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
Гишүүд:	Э.Мөнх-Эрдэнэ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
	Б.Дархантөр	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
	Б.Сүнгээ	Мэргэжлийн хяналтын газрын дарга
	Г.Сэдэдмаа	Статистикийн хэлтсийн дарга
	Б.Хэрлэнчимэг	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга

2.

Э.Хонгорзул	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Ж.Энх-Амгалан	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Н.Анхбаяр	Мал эмнэлгийн газрын дарга
О.Цэндгомбо	Онон, балжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны газрын дарга
М.Шүрэнцэцэг	Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч
Д.Баянмөнх	Баян-Овоо сумын Засаг дарга
О.Лхагвадорж	Баян-Адарга сумын Засаг дарга
А.Мөнхбайгаль	Норовлин сумын Засаг дарга
Б.Нандинцэцэг	Хэрлэн голын сав газрын захиргааны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Т.Алтанчимэг	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн
Ж.Цэнджав	Аймгийн Жендэрийн салбар хорооны гишүүн
Б.Цэрэнчимэд	Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хоршоологчдын холбооны тэргүүн
Д.Батболд	Онон мөрний нөхөрлөлүүдийн холбооны дарга
З.Ууганбаяр	Аймгийн байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүдийн нэгдсэн холбооны дарга

2.Ажлын хэсэг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон Баян-Адарга, Баян-Овоо, Норовлин сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний төслийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар тус тус хэлэлцүүлж, холбогдох саналыг тусган төлөвлөгөөнүүдийн төслийн эцсийн хувилбарыг 2022 оны 10 дугаар сард багтаан дуусгаж аймгийн Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Батсайхан)-д даалгасугай.

3.

3.Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зорилгоор санхүүжүүлэх эх үүсвэр, хариуцах эзнийг төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тодорхой тусгаж, батлагдсан аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор жил бүр мониторинг хийж аймгийн Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Батсайхан)-д даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2021 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн А/432 тоот захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ